

БУДДЫН ШАШНЫ НӨЛӨӨ МОНГОЛЧУУДЫН ГАЛЫН ТАХИЛГАД ТУССАН НЬ

Д.БЯМБАДОРЖ
МУИС-угсаатны зүйн тэнхим

Галын шүтлэг нь Азийн олон ард түмний эртний шүтлэгийн нэг бөгөөд XVIII зууны дунд үед амьдарч асан Урадын Мэргэн даяанч лам Лувсандамбийжалцан бээр:

... Үлэмж энэрэнгүй аугаа галын хаан
Үнэнч шулуун буянт галын тэнгэрийг
Энэтхэгийн орноо дээдлэн шүтдэг ажгуу ...
... Эрхэм дээд галын сахиулсан
Эрэлхэг хүчит арш тэнгэрийг
Эгээ мөн төвдүүд бишрэн тахьдаг ...
Сүр ихт галын сахиулсан
Хиргүй ариун арш тэнгэрийг
Хятад нангидууд ч хүндлэн тахьдаг ажгуу

хэмээн Монголын хөрш зэргэлдээ орнуудад ч галыг бурханчлан шүтдэг, галд зориулан тайлга, тахилгын зан үйл хийдэг байсан тухай бичиж үлдээсэн байна.

Монголын гал тахилгын сан судрын бүтэц зохиомж, дүр дүрслэл, өгүүлэлмжид Энэтхэг Төвдийн буддын шашны ертөнцийг үзэх үзлийн тусгал ойлголтууд орсныг бид ажиглаж болно. Энэ нь Монголд буддын ба ламын шашин удаа дараагаар дэлгэрч байсан өнө эртний болон хожуу үеийн түүхэн цаг үе, үйл явцтай холбоотой юм.

Алив шашин үүсэн төлөвших, дэлгэрэн тархаадаа тухайн нутгийн оршин суугчдын хуучин шүтлэг, шүтлэгийн зан үйлийг бүрэн шахан устгаж чаддаггүй, харин ч шингээн хувиргаж авдаг болох нь эдүгээ цагийн дэлхийн голлох шашин Христосын /Загалмайн/, Буддын, Лалын /Ислам/ шашны түүх, зан үйлийн судалгааны баримтаас хялбар ажиглагдана. Өөрөөр хэлбэл шинэ орон зайд тархан дэлгэрч буй шашин шинэ нөхцөлд зохицохын тулд хуучин шүтлэгийн зан үйл, үндсэн ойлголтыг шинээр тайлбарлах /өөрийн шашны үзэлд зохицуулан/ явдал аль ч шашны түүхэнд хангалттай олон байна. Хэлбэр агуулгаа шинэчилсэн эртний шүтлэгийн элементүүд нь шинэ шашны хөрс болж өгдөг байна.

Төвдөд буддын шашныг анх дэлгэрүүлсэн Энэтхэгийн их бандида Бадамсамбхава /лам Padmasambhava, төвд Padma byiing gnai м Линхуа гарах орон/ (8-р зуун) 25 шавийн хамт аргын 775 онд Төвдөд бурхны шашны анхны хийд – Самъяа хийдийг босгох цагт төвдийн газрын эзэд (Sabdas) хилэгнэж гал усны аюул, газар хөдлөлт зэргийг үүсгэж галзуу араатны дүрээр хувилан ирэх зэргээр сүйтгэхэд Бадамсамбхава ид шидийн хүчээр тэднийг номхотгож бурхны шашныг сахин хамгаалах тангаргийг нь авч “Таван хаан” хэмээх буддын шашны сахиус болгосон гэсэн домогтой. Энэ домог нь Ловон Бадамжуайн төвдийн уламжлалт Бон шашны сахиусан бурхдыг шинэ шашинд зохицуулан өөрчилсөн үйл ажиллагаатай холбоотой домог бөгөөд энэ бүгдийн дүнд Төвдөд бон шашин буддизмын зөрчил багасч буддизм төвдөд үндэслэхэд чухал түлхэц болсон байна. Ингэж буддизм бон шашины тай холилдсон талаар Туган Дармабазар “... Ном хийгээд бон хэмээх харшилсан мэт үйлдэх боловч номд /буддизмд С.Б/ бон, бонд ном хольцолдсон тул номын нүдэн тоос лугаа хагацсан үгүй миний мэт бээр ном бонгийн тийн ялгалыг үйлдэхээн мэдрэв” хэмээн өгүүлсэн байна.

Хүн амын дийлэнх хэсэг нь бөө мөргөлтэй монгол оронд XVII зууны үед Буддизм амжилттай дэлгэрсэн явдлыг зөвхөн бурхны шашны энэрэнгүй шинж, монголын төрийн зүгээс дэмжлэг хүлээж байсан зэргээр тайлбарлах нь учир дутагдалтай бөгөөд буддын шашин бөө мөргөлийг шахаад лам нар бөө мөргөлийн зан үйлд буддын шашны тайлбар хийж, буддын шашны хальсаар халхалж хувиргасан явдал чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Үүнийг бид монголчуудын гал тахилгын жишээгээр авч үзье.

Монголчуудын гал тахилгын судрыг шашны нөлөө туссан байдлаар нь Бурхны шашны нөлөө үлмэж туссан. Бөө мөргөлийн гал тахилгын судрын агуулгыг үндсэнд нь хадгалан буддын шашин, Энэтхэг төвдийн соёлын зарим ойлголтыг шигтгэн өнгөлсөн, буддын шашны нөлөө тусаагүй гэж ерөнхийд нь хувааж болох ба эхний хэсэгт Цахар гэвш Лувсанцүлтэмийн “Гал тахилгын зан үйл баясгалан гарахын орон”, Мэргэн гэгээн Лувсандамбийжалцангийн “Галын ерөөл оршив” зэрэг хожуу үеийн лам нарын зохиосон сан судар, сүүлийн хэсэгт ганц нэг тарни, маани, Эртний Энэтхэгийн гаралт, монголын аман соёлд эрт дээр үеэс нэвтрэн идээшсэн “Сүмбэр уул, Сүн далай ...” мэтийн ойлголтыг эс тооцвол цэвэр бөө мөргөлийн шинжээ хадгалсан маш цөөн судрыг оруулж байна. II хэсэгт олонх сан судрын дурсгал багтаж байна. Өвөр монголын эрдэмтэн Ч.Булагийн эмхэтгэсэн “Гал тахилгын сан судар оршвой” номонд орсон судраас Хувь нь

Олон судар гал тахилга эхлэхийн өмнө “Өөрийн нэгэн эгшинд Доржсэмбийн бие болов” хэмээн бясалгах, Энэтхэг хэлээр (*na mo dxarmgya. Na mo buddhaya namo sanghaya*) номд итгэмүй. Бурханд итгэмүй. Хуврагт итгэмүй хэмээн өгүүлэх буюу “Тус амгалан хоцролгүй гарахын орон чухаг дээд гурван эрдэнэд итгэмүй хэмээн итгэл явуулах мөн “хамаг амьтны тусын тулд Түргэнээ бурхан болтугай “Ум сайн амгалан болтугай” гэсэн ерөөлийн үгээр эхэлдэг нь бурхны шашны уламжлалд буй алив сан судар унших зохиох, зан үйл үйлдэхийн өмнө лам гурван эрдэнэ (*dkon mchig gsum*) буюу Бурхан багш (*sans rgyas*), ном (*G cos*), хувраг (*dge dun*) нарт итгэл явуулдаг, ямар нэг бурхан бодьсад болов хэмээн бясалгах ёстой холбоотой байна.

Монголчуудын уламжлалт сэтигэлгээнд галыг ертөнцийн хэлбэрээр нь амьдчилан үзэж бурханчлан шүтдэг.

“шар тосон царайт
шар хялгана идэшт
торгон нүүрт
toson amyt
ан торгон амьсгалт
халуун улаан хэлт
хайчин дүрст галайхан эх”
“жаргах нарны гэрэлт”
“өвс тосон гэрэлт
өөх тосон идэшт
“онон хэлт атхан эцэг
ганц хэлт гал эх” гэх буюу
хатууг түлэгч
харанхуйг гийгүүлэгч
хайр чулуун эхт
хатан төмөр эцэгт
холтсон модон амьтай
үүл нэвт униартай
этүгэн нэвт мичит
гал галайхан эх

гал тэнгэрийн дүрслэл нь галтайгаа ялгарах юмгүй яг адилхан бөгөөд галын тэнгэр нь галтай адил халуун, гэрэл, утас бүхий улаан заль дөл бадруулсан байдаг.
/Галданова 1967. 150/

Энэ гал нь байгалийн	“Чин чулуун эхт Чингис төмөр эцэгт Хайр чулуун эхт Хатан төмөр эцэгт Хатан болд эцэгт Хайр чулуун эхт
----------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------

бүтээх ба түүнийг Есүхэй баатар, Чингис бөгд, Цагаадай, Өгөдэй, Тулуй, Мөнх, Хубилай зэрэг Монголын хаад өвөг дээдэс асааж /цахиж/ Өүлэн, Бертулжин, Хулан, Цанхулан, Сутай, Чимбай, Монгол гоо, Сутай хатны үлээн бадраасан гал юм. Эдүгээ хүртэл хуримын ёсонд нөхөр нь цахиж, эхнэр нь хөгжөөн дэвжээж асаадаг заншил уламжилсаар иржээ.

Монгол домог зүйн ойлголтод хожим Энэтхэгийн соёлын нөлөө тусч гал нь “газар тэнгэр хоёрын дундаас өөрөөн төрсөн” чанарт болсон тухай сударт “Ариун чанарт хий мандал шатаж бүрэн асар таван билэг билгийн гал бадарснаар гадаад сав ертөнцөд хийгээд харин дотоод шим амьтан хамт таван махбодоос үүдсэн гайхамшиг гэгээн гэрэлт бүтээлийг эргэхүй хурдний язгуураас эрхэн дүрт хан хийгээд дөрвөн язгууртан эрих, зүүн мутараа рашаанаар дүүрсэн Гүнда нэрт хумх барьсан цагаан тортон дээл өмссөн цагаан тортон сугавч лянхуа суудлаар суусны гадуур эрхи лугаа адил дүрт олон нөхдөөр хүрээлсэн бүгдийн зүрхэнд рам үсэгтэй болой” хэмээсэн үүнд Эрт энэтхэгийн аршисын дур тодорхой байгааг

Амь насыг уртасгах ивээхийн тулд
Аршийн дүрт биеийг үзүүлсэн
Ад зэтгэр тэргүүтнийг амирлуулахын тулд
Асар цагаан өнгөөр хувилснаа магтмуу
Үгүйрэхийн зовлонгоос аврахын тулд
Үлшгүй рашаант хумх бариад
Үлэмж жаргалд удирдахын тулд
Үзэсгэлэнт эрих барьснаа магтмуу

Дүрслэлийн ерөнхий хэлбэр нь энэтхэгийн дүвчин шидтэнгүүдийн дүртэй тохирч байна. Галын бурхан өөр нэг дүрслэл нь “Улаан царайтай хоёр гартай, гурван нүдтэй, хөмсөг сахал нь гал ноцож байгаа мэт улбар шар буюу алтан шар сэрг унаад баруун гартаа эрих, зүүн гартаа хумх барьсан байдаа” хэмээсэн нь “буддын бурхан дүрслэлд “төвуун дүрт” бурхдын нэг төрөл болох ”... байдалтны” дүртэй тохирч байна. Буддын шашны хангаль бурхдын нэг Очирваань бурхныг дүрслэхдээ: ...

Үүнээс гадна гал тэнгэрийг “Галын цагаан охин тэнгэр нар

Оюу хөмсөтт
Лавай шүд хийгээд
Болор бүстэй
Сувд сүйхтэй
Гүүжин хамартай

Сэргийн дээр суудалт
Шар тосон идэшт
“Хөх мөнх отторгуйд
Хүрмэл гэрэлт болсон
Очирваанийн царайт
Олон амьтны гэрэл болсон”

гэх мэтээр олон янзаар дүрсэлсэн нь бүгд буддын шашны нөлөө туссан байна. Бөө мөргөлийн гол шүтээн болох Хөх тэнгэр, Хөрст дэлхийгээс гал үүссэн гэж үздэг бол хожим лам нар энэ ойлголтыг өөрчлөн хувиргаж хөх мөнх тэнгэр, хөрст этүгэн эхийг Варузана тэнгэр, Васудари эх хэмээн самгарди гаралтай тэнгэрсээр солих, Мөнх тэнгэрийн үүсгэгч үүргийг “Вишну тэнгэрээс болсон бишрэлт ардын тахьсан Махасувари тэнгэрээс болсон маш олон иргэдийн тахьсан” гэхчлэн ведийн шашны гаралтай, буддын шашны тэнгэр хэмээх ойлголтод нялзаан дүйцүүлж саармагжуулсан байна. Сударт Хурмаст тэнгэр хэмээн нэрлэгдэж буй тэнгэр нь монголын бөө мөргөлийн барууны тавин таван тэнгэрийн ахлагч тэнгэрийн утгаа алдаж буддын шашны зуун өглөгт тэнгэр буюу ведийн шашны гаралт Индра тэнгэр болох нь илт байна. Эртний вед шашны ойлголтоор нар, сар, гал гурвыг өөрөө үүдсэн /сваямбху/ хэмээн үздэг ба ертөнцийн махбод бүр нэгэн шидэт үсгээс үүдсэн бөгөөд энэ нь гал тахилгын сударт олонтоо тааралдаж байна. Галыг арш исын увдисаар бүтсэн Рам үсгээс үүдсэн” гэж дүрсэлсэн нь элбэг тохиолдож байна. Буддын шашинд ертөнцийн үүслийн талаар өгүүлэхдээ “... гурван зүйл мандлаар тогтов. Түүнд гурван мандал нь зохиогч хийн мандал, долгилогч усан мандал, шүтүүлэгч шороон мандал лугаа гурваас, арван зүгээс их хий хөдлөн нааш цааш хөдлөн тулалдсанаас Зөөлөн нэрт хөхөмдөг өнгөт хэн бээр үл буртаглахуй нэгэн хийн мандал болон тогтов гэдэг бол гал тахилгын сударт” Арван зүгийн хий хийсэхээс Алман нарны гэрэл тогтохоос Алтан дэлхий тогтон байхаас Амьтны заяа дөрвөн язгуур улс болохоос үүдсэн... гал галайхан хэмээн дүрслэгдсэн байна. Мөн дөрвөн махбод, ертөнц үүссэн тухай нэгэн домогт “Эрт цагт нэг их мэлхий хойноос урагш явж байхад нь нэг их баатар мэлхийг харважээ. Сум нь мэлхийн баруун сүвээгээр орж зүүн сүвээгээр нь сүвлэн цухуйжээ. Мэлхий нэг хөрвөөгөөд гэдрэг харж үхэхэд баруун талаас нь төмөр зэв, зүүн талаас нь өдтэй модон сум цухуйж амнаас нь гал бадран сүвнээс нь ус гарч дөрвөн зүг, дөрвөн махбод тогтох дөрвөн сарвуунд атгасан шороо нь завсрын шороон зүгийг бий болгожээ” хэмээсэн байна. Үүнийг гал тахилгын сударт “Алтан мэнэхэйн тэргүүн дээр Ли үсэг болон хувилсан” гал хэмээн өгүүлсэн байдаг. Мөн үүнээс гадна галыг хотол амьтны тул хутагт бурхан багшийн хувилгаанаар үүдсэн гэх буюу “Бадамсамбава багшийн зохиосон

Галын хаан Миранза минь...”, Эрхэт Шигимунь бурхны цахисан Галын хаан миранза минь ...”, “Шигимунь бурхны цахисан

Шидэт дагинасын үлээсэн
Бурхан багшийн зохиосон
Бүд дагинасын үйлдсэн
Раднаасамбхавагийн зохиосон
Раднаа дагинасын үйлдсэн
Гашив бурхны үйлдсэн
Гэрэл дагинасын үйлдсэн
Оточ бурхны зохиосон
Удвал дагины үйлдсэн
Отхан галайхан эх минь
Хуурмаст тэнгэрийн зохиосон
Хоншим бодьсадын үлээн ноцоосон

Хотол замбуутивд гал болон шүтэгдсэн гэх мэтээр хүний бүтээл /цахисан, үлээсэн/ бүтээл байснаа бурхдын бүтээл болон хувирсан байна. Бөө мөргөлийн сан сударт галыг “Отхан галайхан эх”, “Гал галайхан эх”, “Гал тэнгэр” хэмээн нэрлэдэг байсан бол хожуу үед энэтхэг төвдийн нөлөө тусч “Галын хаан миранза”, “Арш тэнгэр”, “Агни тэнгэр” гэж нэрлэх болсон байна.

Галын үүслийн цаг нь монголын домгийн цагтай давхцдаг бөгөөд

Дээр хөх мөнх тэнгэрийн
Тэвшин чинээ бүхийгээс
Доор Этүгэн эхийн
Өлмийн төдий бүхийгээс...
Хангай ханыг довон бүхийгээс
Халтар тэхийн үнүгэн бүхийгээс
Хайлаас модны найлзуур бүхийгээс
Харцага шувууны дэгдмэл бүхийгээс
Хамаг улсын хүүхэн бүхийгээс ...

гэхчилэн Алтай Хангай уул, Бурхан халдун, Бургат хан, Хөхий хан уулсыг дов толгой, хөтөл, тэх, аргаль, угалз хандгайг ишиг, хурга, тугал төдий, ус мөрөн /Хатны гол гм/ далайг шалчиг шалбааг бүхий үед гал үссэн гэж үздэг бол Энэтхэгийн домог зүйн уламжлалт ойлголт болох Сүмбэр уул, Сүн далай, Ганга мөрөн, Галбинга шувуу, Гарди, Галбарваасан зандан мод, Бодь зандан мод, Бодьсад бурхад, Төвдийн Далай лам зэрэг ойлголтуудыг сүлжилдүүлэн шигтгэн оруулсан байна. Галыг хүн дүрстэй дүрсэлсэн явдалд буддын шашны бурхан дүрслэлийн нөлөө бүр тод үзэгдэж байна. Галын бурхныг “Өмнөд огторгуйд рам үсгээс болсон галын цогцын дунд ялангуяа саран дээр гал тэнгэр цагаан өнгөтэй, маш амирлангуй дүртэй, цагаан үсээ орой дээрээ зангидсан битүү цагаан сахалтай баруун мутартаа цагаан шил эрхи, зүүн мутартаа рашаанаар дүүрсэн Гүнда нэrt хумх барьсан цагаан тортон дээл өмссөн цагаан тортон сугавч лянхуа суудлаар суусны гадуур эрхин лугаа адил дүрст олон нөхдөөр хүрээлсэн бүгдийн зүрхэнд “рам” үсэгтэй болой” гэх буюу

Амь насыг уртасган ивээхийн тулд
Аршийн дүрт биеийг үзүүлсэн
Ад зэтгэр тэргүүтнийг амирлуулахын тулд
Асар цагаан өнгөөр хувилсанаа магтмуу.
Үгүйрэхийн зовлонгоос аврахын тулд
Үлшгүй рашааны хумх бариад
Үлэмж жаргалд удирдахын тулд

Үзэсгэлэнт эрхи барьснаа магтмуу” хэмээсэн үүнд буддын шашны пантеонд орсон эрт энэтхэгийн дүвчин шидтэн, арш исын дүрслэл илт байгаа бол “Улаан царайтай, хоёр гартай, гурван нүдтэй, хөмсөг сахал нь гал ноцож байгаа мэт улбар шар буюу алтан шар сэрх унаад баруун гартаа эрхи, зүүн гартаа хумх барьсан” дүр нь буддын шашны бурхан дүрслэлийн “томуун” дүрт бурхад багтах байдалтны дүрслэлтэй тохирч байна. Буддын шашны хангал бурхдын нэг болох Очирваань бурхныг дүрслэхдээ “Очирваанийн биеийн өнгө хар хөхөмдөг, индранилын ууланд буман нарны туяа туссан мэт сүр жавхлан тэсэхүүеэ бэрх, амаа машид ангайгаад дөрвөн хурц соёогоо ярзайлгаж хэлээ сайтар хуйлруулан ... хатуу чанга дууг луу мэт дурсгаад бөөрөнхий улаан гурван нүдээ гилблэлгэн мэт гилбийлгэж, уурсан хилэгнэсэн, хөмсөг, сормуус, оройн үснир нь улаан шар эцэс цагийн гал мэт бадарсан, баруун гарынхаа занах хуруу лугаа сэлтээр таван салаат очирыг огторгуйд шааснаар ... зүүн гарсаа зүрхэн тус газраа атгаж....” гэж дүрсэлсэн бол Бэгз Жамсранг “... амаа машид ангайгаад дөрвөн соёог ярзайлгаж... гурван нүд лүгээ төгөлдөр бөгөөд уурсан хилэгнэсэн ихэмсэг баатрын ширүүн дүртэй... бэлгэ билгийн гал бадарсны төв дунд оршсон” хэмээн дүрсэлсэн нь эрхгүй галын тэнгэр, буддын шашны догшин бурхдын дүрслэлийг харьцуулан үзэхэд хүргэж байна. Үүнээс гадна гал тэнгэрийг

“Галын цагаан охин тэнгэр нар
Оюу хөмсөгт
Лавай шүд хийгээд

Болор бүстэй
Сувд сүйтэй
Гуулин хамартай
Сэргийн дээр суудалт
Шар тосон идэшт
Хөх мөнх огторгуйд
Хүрмэл гэрэл болсон
Очирвааний царайт

Олон амьтны гэрэл болсон гэхчлэн олон янзын дүрслэл нь буддын шашны нэлөө туссаныг ажиглаж болно.

Бөө мөргөлийн агуулгад сударт туссан буддизмын нэлөөг ажиглахад ихэвчлэн заллага, өчиг, даллага, ерөөлийн хэсэгт шашны агуулгатай хэсгүүд тааралдаж байна. Үүнд: Шагжмуни бурхнаас үнэн номын буян хишиг, Очирваань тэргүүт хамаг догшдын буян хишиг, Охин тэнгэр тэргүүт хамаг сахиусны буян хишиг, Очирдарь тэргүүт хамаг бурхдын өлзий хутаг, Нууцын хураангуй тэргүүт хамаг ядам бурхдын тарнийн хутаг, Баатар дагинасын шидийн хутаг, Даяаны таван бурхан, Эсрэн хурмаст тэнгэр, Бясман тэнгэр, Наганзуна тэргүүт 88 шидтэн, Найман түм, дөрвөн мянган номын хишиг, Үнэн дээд гурван эрдэнэс хишиг, Урд хойд насны хутаг, Сухавадийн орны жаргал, Дээд зүгийн тэнгэр нар дэргэд аху хамаг сахиусан, дэлхийд аху газрын эздийн дэмжлэг асралыг эгээрэн хүсч орчлонгийн хамаг амьтныг хүсэмжлэн ерөөсөн, гүйсан байна.